

“ESG FINANCE” JSC

“И ЭС ЖИ ФАЙНАНС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 4 -р сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

“И Эс Жи Файнанс” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 4-р сарын 30-ны өдөр 12 цагт Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Худалдааны гудамж, Дельта төв 5-р давхар, 502 тоот өрөөнд хийж ба хувьцаа эзэмшигчдийг холбогдох журмын дагуу бүртгэн авч ирцийг тооллогын комисст хүлээлгэн өгөв.

Хурлыг тус Хурлын дарга М.Сайнболор нээв.

-Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид та бүхэнд талархал илэрхийлье.. Та бүхэнд тооллогын комиссоос гаргасан хурлын ирцийг танилцуулъя. Компанийн нийт 374,018 ширхэг хувьцааны 90.2% буюу 337,624 ширхэг хувьцааг эзэмшигчид ирсэн тул хурлыг хүчинтэйд тооцож эхлүүлэе.

Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ. Үүнд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн 2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах
4. Нэмэлт хувьцаа гаргах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх
5. Ногдол ашиг хувиарлах эсэх тухай тайлагнах
6. Жи эф жи файнэнс ХХК, Жи эф жи иншурэнс ХХК-ийн үүсгэн байгуулагчаас хасагдах тухай
7. Бусад.

Хурлын дэгийг танилцуулъя. Хуралаар хэлэлцэх асуудлын жагсаалтын дагуу явагдана. Ингээд хурлаар хэлэлцэх эхний асуудал болох “Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан” – гийн талаар Гүйцэтгэх захирал М.Сайнболор танилцуулна. Гүйцэтгэх захирал, хурлын дарга М.Сайнболор

Компанийн үйл ажиллагааг зогсонги байдлаас гаргах үүднээс үйл ажиллагааны үндсэн чиглэлд өөрчлөлт оруулах болон ногоон хөгжил, хиймэл оюун ухаан, финтек салбарт судалгааны ажил хийж байна. 2026 онд компани мэдээлэл технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар ажиллаж байна. Монголын Хөрөнгийн Бирж, Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК-ийн гишүүнчлэл, хувьцаа хадгалалтын төлбөрүүдийг төлж барагдуулсан. Зарим нэгэн компани аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулахаар ажиллаж байна. Тендерт орохоор бэлдэн хэд хэдэн тендерт оролцохоор бэлдэж байна.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үйл хүрээнд компанийн үйл ажиллагааны чиглэл болон стратегийг гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдад танилцуулах ажлууд шат дараатай зохион байгуулагдсан.

Компаниудад вэбэд суурилсан програм хангамж хөгжүүлэх болон мэдээлэлийн технологийн шийдлийн зөвлөгөөг өгч байна.

Бид цаашид: ESG ногоон хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх, хамтрах, хиймэл оюун ухаанд суурилсан шинэ үйл ажиллагааг нэвтрүүлэхээр ажиллаж байгаа ба нэмэлт хувьцаа гарган хөрөнгө оруулалт татах шаардлагатай байна.

Хурлын дарга М.Сайнболор: Та бүхэнд асууж тодруулах зүйл байна уу. Та бүхэнд тараагдсан байгаа үйл ажиллагааны төлөвлөгөө болон санхүүгийн тайлантай танилцаад асуух зүйл байвал асуугаарай.

Хувьцаа эзэмшигчид: Байхгүй эздэмжиж байна.